



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны "Ахуйн үйлчилгээний цэгийн 20... оны хагас, бүтэн жилийн мэдээллийн маягт, нөхөх заавар зөвшөөрөх тухай" А/174 дүгээр тушаал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Дэд хөтөлбөр батлах тухай" 16/07 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Захиргааны статистикийн мэдээллийн маягт батлах тухай" А/120 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 4 дүгээр хэсгийн 4.6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" нийслэлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахуйн үйлчилгээний захиргааны мэдээллийн маягтыг хэвлэн олшруулж дүүргүүдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтэс /Д.Оюунболор/-т үүрэг болгосугай.


2. Дээрхи арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг хавсралт ёсоор баталсугай.

3. Хавсралтаар батлагдсан 2 000 000 /хоёр сая/ төгрөгийг бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2020 оны *Одоогоор* сарын *12* өдрийн  
*11/46* тушаалын хавсралт



АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН 20... ОНЫ ХАГАС  
БҮТЭН ЖИЛИЙН ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЛИЙН  
МАЯГТ ХЭВЛҮҮЛЭХ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	ААН-ийн тоо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төгрөг/
1	Ахуйн үйлчилгээний цэгийн 20... оны хагас бүтэн жилийн захиргааны мэдээллийн маягт хэвлүүлэх - А4 хэмжээтэй, ар өвөргүй, 2 хуудас	4155	10000	200	2000000
Нийт дүн					2000000